



Бизнесийн Ёс Зүйн Алба

Бие Даасан Гишүүний Биеэ авч явах Дүрэм. Асуулт ба Хариулт

Энэхүү гарын авлага нь хамгийн түгээмэл асуултуудын нэг болох “Давхар гишүүнчлэл”-ийн тухай болно.

Таны шинэ үйлчлүүлэгч Бие Даасан Гишүүн болохыг хүсч байгаа ч, урьд нь компанитай гэрээ байгуулж байсан бол яах вэ? Ийм нөхцөлд ямар нэг зөрчил гаргахгүйн тулд үйлчилүүлэгчдэд гэрээний дүрмийг сайтар ойлгуулах нь маш чухал байдаг.

Хэрэв ямар нэг шалтгаанаар Компанитай байгуулсан гэрээгээ цуцалсан гишүүн нь дахин Herbalife Nutrition-ы Бие Даасан Гишүүн болохоор шийдсэн бол дараах сонголтыг санал болгодог:

- Өмнөх гэрээгээ сэргээж, хуучин спонсорттойгоо хамтран ажиллах
- Идэвхигүй байх хугацаа нь дууссан бол өөр спонсорын дор шинэ гэрээг байгуулах

Өмнөх спонсорттойгоо үргэлжлүүлэн хамтран ажиллах нь хамгийн тохиромжтой сонголт юм. Спонсор ба түүний Бие Даасан Гишүүн хоорондын харилцаа нь Herbalife Nutrition компанийн бизнесийн гол тулгуур бөгөөд компанийн борлуулалт, маркетингийн төлөвлөгөөний дагуу эрсдэлгүй бизнесийг бий болгодог. Бид эхний Спонсорын эрхийг хамгаалахыг зорьдог тул энэ төрлийн зөрчилд онцгой анхаарал хандуулдаг. Ийм төрлийн зөрчил нь ихэнхдээ Спонсор нь дүрмийг буруу тайлбарлах, идэвхигүй байх хугацааг буруу тооцоолсонтой холбоотой үүсдэг.

Энэхүү зөрчлөөс зайлсхийхэд тань туслах зорилгоор уг гарын авлагад бид Давхар Гишүүнчлэлтэй холбоотой ихэнхи тохиолддог Асуулт, Хариултуудыг танд толилуулж байгаадаа баяртай байна.

- **Давхар Гишүүнчлэлтэй холбоотой ерөнхий дүрмүүд**
- **Идэвхигүй байх хугацаа**
- **Гэрлэсэн хос болон хоорондоо гэр бүл болж буй Гишүүд**
- **Давуу эрхт үйлчлүүлэгч ба Идэвхигүй байх хугацаатай холбогдох дүрэм**

Давхар гишүүнчлэлтэй холбоотой ерөнхий дүрмүүд

1. Бие даасан гишүүн хоёр өөр спонсорын дор тус тус гэрээ байгуулж болох уу?

Болохгүй. Бие даасан гишүүд зөвхөн нэг гишүүнчлэлийн гэрээний дагуу бизнес эрхлэх боломжтой.

2. Бие даасан гишүүн нэг спонсорын дор хоёр гэрээ байгуулж болох уу?

Болохгүй. Бие даасан гишүүд зөвхөн нэг гишүүнчлэлийн гэрээний дагуу бизнес эрхлэх боломжтой.

3. Хоёр спонсорын дор тус тус гэрээ байгуулсан Бие Даасан Гишүүдэд ямар арга хэмжээ авдаг вэ?

Дүрмийг зөрчсөн тохиолдолд авах арга хэмжээ:

- Дүрмийн дагуу байгуулагдаагүй гэрээг цуцлах;
- Статусыг шилжүүлэх, Оноо болон доод баг командын Гишүүдийг анхны баг команд руу шилжүүлэх;
- Дээд баг командын спонсорт олгогдсон урамшууллыг анхны баг команд руу шилжүүлэх;

4. Бие Даасан Гишүүн болон түүний ээж хоёр өөр спонсорын дор бизнесээ эрхэлдэг. Тухайн Бие Даасан Гишүүн ээжийнхээ бизнесийг хөгжүүлэхэд нь тусалж болох уу? Жишээлбэл, ээжийнхээ захиалгыг хийж өгөх, төлбөрийг төлөх, үйлчлүүлэгчдэд нь зөвлөгөө өгөх, үйлчлэх гэх мэт.?

Болохгүй. Бие Даасан Гишүүд зөвхөн өөр өөрсдийн гэрээний дагуу бизнесээ эрхлэх боломжтой бөгөөд бусад Бие Даасан Гишүүдийн бизнесийг хөгжүүлэхэд оролцохыг хориглодог.

Идэвхигүй байх хугацаа

5. Бие Даасан Гишүүн гэрээгээ цуцалж, даруй өөр спонсорын дор дахин шинэ гэрээ байгуулахыг хүсч байна. Ингэх боломжтой юу

Хэрэв Бие Даасан Гишүүн гэрээгээ ямар нэгэн шалтгаанаар цуцалсан бол өөр Спонсорын дор дахин Бие Даасан Гишүүн болохын тулд идэвхигүй байх хугацааг дуусгахыг хүлээх шаардлагатай. Та компанид хандан идэвхигүй байх хугацааг зөв тооцуулах шаардлагатай.

Ямар нэгэн дүрмийн зөрчил гаргахгүйн тулд Идэвхигүй байх хугацааг Бие Даасан Гишүүн өөрөө тооцохыг зөвлөдөггүй.

6. Идэвхигүй байх хугацаа гэж юу вэ?

Идэвхигүй байх хугацаа гэдэг нь хуучин Бие Даасан Гишүүд, тэдний эхнэр, нөхөр эсвэл хамтран амьдрагч Herbalife Nutrition-ы бизнес эрхлэх, сурталчлах болон Бие Даасан Гишүүний шинэ гэрээ байгуулах боломжгүй хугацаа юм.

Мөн Давуу эрхт үйлчлүүлэгч нь өөр спонсорын дор Давуу эрхт үйлчлүүлэгчийн хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй бол Идэвхигүй байх хугацааг дуусгах ёстой.

7. Идэвхигүй байх хугацааг хэрхэн тооцох вэ?

Үйлчилгээний жилийн Гишүүнчлэлийн хураамжаа төлснөөр Бие Даасан Гишүүн нь гэрээнийхээ үйл ажиллагааг нэг жилээр сунгадаг. Гишүүнчлэлийн хураамжаа төлөөгүй тохиолдолд Гэрээг идэвхигүйд тооцно. Хураамж төлөгдөөгүй өдрөөс хойш идэвхигүй байх хугацааг эхлүүлэхдээ Та Herbalife Nutrition-ы бизнестэй холбоотой бүх үйл ажиллагаагаа бүрэн зогсоох ёстой.

Хэрэв Бие Даасан Гишүүний гэрээг түүний компанид бичгээр гаргасан өргөдөлд үндэслэн цуцалж байгаа бол компани Бие Даасан Гишүүний өргөдлийг хүлээн авсан өдрөөс эхлэн Идэвхигүй байх хугацааг тооцно.

Идэвхигүй байх хугацааг зөв тооцоолохын тулд та компанид хандах нь зүйтэй. Ямар нэг алдаа гаргахгүйн тулд Идэвхигүй байх хугацааг Бие Даасан Гишүүн өөрөө тооцохыг зөвлөдөггүй.

8. Идэвхигүй байх хугацаа хэр удаан үргэлжилдэг вэ?

- Супервайзор болон түүнээс доош статустай Бие Даасан гишүүн: Идэвхигүй байх хугацаа нь Гэрээг цуцалсан эсвэл гишүүнчлэлийн жилийн хураамж төлөгдөөгүй өдрөөс хойш 1 жил;
- World Team ба түүнээс дээш статустай Бие Даасан Гишүүн: Идэвхигүй байх хугацаа нь Гэрээг цуцалсан эсвэл Гишүүнчлэлийн жилийн хураамж төлөгдөөгүй өдрөөс хойш 2 жил;

Идэвхигүй байх хугацааг зөв тооцоолохын тулд та компанид хандах нь зүйтэй. Ямар нэг алдаа гаргахгүйн тулд Идэвхигүй байх хугацааг Бие Даасан Гишүүн өөрөө тооцохыг зөвлөдөггүй.

9. Идэвхигүй байх хугацаанд ямар үйл ажиллагаа явуулахыг хориглодог вэ?

Идэвхигүй байх хугацаанд Бие Даасан Гишүүд дараах зүйлсийг хийхийг хориглоно:

- Herbalife Nutrition-ы бизнест ямар нэгэн байдлаар оролцох;
- Herbalife Nutrition-ы бүтээгдэхүүн, хэвлэмэл материалыг тараах, борлуулах;
- Шинээр Бие Даасан Гишүүн элсүүлэх эсвэл Herbalife Nutrition бизнесийн боломжийг санал болгох;
- Herbalife Nutrition-ы бусад Бие Даасан Гишүүдийн бизнест ямар нэгэн байдлаар оролцох;
- Herbalife Nutrition-ы Бие Даасан Гишүүдэд зориулсан сургалт, арга хэмжээнд оролцох;
- Давуу эрхт үйлчлүүлэгчийн хөтөлбөрт хамрагдах;

10. Идэвхигүй байх хугацаанд ямар үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрдөг вэ?

Идэвхигүй байх хугацаанд Бие Даасан Гишүүд дараах зүйлсийг хийх боломжтой:

- Herbalife Nutrition-ы Бие Даасан Гишүүнээс бүтээгдэхүүнийг жижиглэнгийн үнээр худалдаж авах;
- Эрүүл амьдралын хэв маягийн клубээр зочлох;
- Үйлчлүүлэгчдэд зориулсан арга хэмжээнд оролцох;

11. Бие Даасан Гишүүн нь өмнөх спонсорттойгоо дахин шинээр гэрээ байгуулахыг хүсвэл идэвхигүй байх хугацаа шаардлагатай юу?

Хэрэв Бие Даасан Гишүүн нь өмнөх спонсорынхоо дор дахин гэрээ байгуулахыг хүсвэл, спонсор нь хуучин баг команддаа байгаа бол идэвхигүй байх хугацааг хүлээх шаардлагагүй.

Гэрлэсэн хос болон хоорондоо гэр бүл болж байгаа Гишүүд

12. Бие Даасан Гишүүний эхнэр/ нөхөр өөр спонсорын дор гэрээ байгуулж болох уу?

Болохгүй. Гэрлэсэн хосууд зөвхөн нэг гэрээн дор бизнесээ эрхлэх боломжтой бөгөөд хэн нэгнийхээ спонсор байх боломжгүй. Хэрэв Бие Даасан Гишүүд хоорондоо гэрлэвэл аль нэг нь Бие Даасан Гишүүнийхээ гэрээг цуцлах ёстой.

16-р асуултыг үзнэ үү.

13. Хамтран амьдрагч гэж хэн бэ?

Хамтран амьдрагч гэдэг нь Herbalife Nutrition-ы Бие Даасан гишүүн өөрийн гэрээнд “Хамтран амьдрагчаар” бүртгүүлсэн Албан ёсоор гэрлэлтээ батлуулаагүй хамтрагчийг хэлнэ.

14. Бие Даасан Гишүүний хамтран амьдрагч өөр спонсорын дор гэрээ байгуулж болох уу?

Болохгүй. Хамтран амьдрагчид зөвхөн нэг гэрээн дор бизнесээ эрхлэх боломжтой бөгөөд хэн нэгнийхээ спонсор байх боломжгүй. Хэрэв хоёр Бие Даасан Гишүүд хамтран амьдрах болвол гишүүнчлэлийн гэрээний аль нэгийг цуцлах ёстой.

16-р асуултыг үзнэ үү.

15. Миний эхнэр/нөхөр өмнө нь Herbalife Nutrition-ы Бие Даасан Гишүүн байсан боловч бизнесээ эрхлээгүй удсан. Би өөр спонсорын дор Бие Даасан Гишүүний гэрээ байгуулж болох уу?

Тийм. Хэрэв таны эхнэр/нөхөр -ийн идэвхигүй байх хугацаа дууссан бол та өөр спонсорын дор Бие Даасан Гишүүний гэрээ байгуулах боломжтой.

Идэвхигүй байх хугацааг зөв тооцоолохын тулд та компанид хандах нь зүйтэй. Ямар нэг зөрчил гаргахгүйн тулд Идэвхигүй байх хугацааг Бие Даасан Гишүүн өөрөө тооцохыг зөвлөдөггүй.

16. Хэрэв Супервайзор эсвэл түүнээс дээш статустай хоёр Бие Даасан Гишүүд хоорондоо гэрлэвэл тэд бизнесээ хэрхэн үргэлжлүүлэх вэ?

Бие Даасан Гишүүд гэрлэх үед хоёулаа супервайзор эсвэл түүнээс дээш статустай байсан тохиолдолд, тэд бизнесээ үргэлжлүүлэн эрхлэх дараах хувилбаруудын аль нэгийг сонгож болно:

- Бие Даасан Гишүүд тус бүр гэрээгээ хэвээр үлдээж, тус тусдаа бизнесээ үргэлжлүүлэх;
- Бие Даасан Гишүүд нэг гэрээн дор бизнесээ үргэлжлүүлж, аль нэг нь гэрээгээ цуцлах;

Давуу эрхт үйлчлүүлэгч ба идэвхигүй байх хугацаатай холбогдох дүрэм

17. Би хоёр өөр спонсорын дор тус тус Давуу эрхт үйлчлүүлэгч хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаж болох уу?

Болохгүй. Давуу эрхт үйлчлүүлэгчийн хөтөлбөрт хамрагдахын тулд нэг хүн зөвхөн нэг хүсэлт гаргах боломжтой.

18. Би нэг спонсорын дор Давуу эрхт үйлчлүүлэгчийн хөтөлбөрт хамрагдах хоёр хүсэлт гаргаж болох уу?

Болохгүй. Давуу эрхт үйлчлүүлэгчийн хөтөлбөрт хамрагдахын тулд нэг хүн зөвхөн нэг хүсэлт гаргах боломжтой.

19. Давуу эрхт үйлчлүүлэгчийн идэвхигүй байх хугацаа хэр удаан үргэлжлэх вэ?

Давуу эрхт үйлчлүүлэгчдийн идэвхигүй байх хугацаа нь Компани уг хөтөлбөрт хамрагдах хүсэлтийг хүлээн авснаас, гишүүнчлэлийн хураамжаа төлсөн өдрөөс, эсвэл сүүлчийн захиалга өгсөн өдрөөс хойш календарын 180 хоног үргэлжилнэ.

Идэвхигүй байх хугацааг зөв тооцоолохын тулд та компанид хандах нь зүйтэй. Ямар нэг зөрчил гаргахгүйн тулд Идэвхигүй байх хугацааг Бие Даасан Гишүүн өөрөө тооцохыг зөвлөдөггүй.

20. Хоёр өөр спонсорын дор давуу эрхт үйлчлүүлэгчийн хөтөлбөрт хамрагдах хүсэлтээ ирүүлсэн Давуу эрхт үйлчлүүлэгчид ямар арга хэмжээ авах вэ?

Хоёр дахь өргөдлийн дагуу ирүүлсэн давуу эрхт үйлчлүүлэгчийн хөтөлбөрт хамрагдах хүсэлтийг цуцална.

21. Давуу эрхт үйлчлүүлэгчийн эхнэр/нөхөр өөр спонсорын дор давуу эрхт үйлчлүүлэгчийн хөтөлбөрт хамрагдах хүсэлт гаргаж болох уу?

Болно, Хэрэв эхнэр, нөхөр хоёрын аль нэг нь Herbalife Nutrition-ы Бие Даасан Гишүүн болвол эхнэр, нөхөр хоёулаа "Давуу эрхт үйлчлүүлэгч"-ийн хөтөлбөрт хамрагдах боломжгүй болохыг анхаарна уу.